АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/92/-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2022 он

Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас:7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор П.Цэцэгдулам
Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал, дүгнэлт
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 15
3.4 Материаллаг байдал ........ 15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 17
3.8 Аудитын гол асуудал ........ 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 19
4. Аудитын илрүүлэлт ........ 19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТЕЗ | Төсвийн Ерөнхийлөн захирагч |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 118

танай ____________-ны № ______________-т

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Л.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 40,120,226.00 | 139,266,315.23 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 10,594,420.42 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 10,594,420.42 |
| 31210 | Төгрөг | 0.00 | 10,594,420.42 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 10,524,420.15 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | 70,000.27 |
| 33 | АВЛАГА | 0.00 | 80,570,900.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.00 | 80,570,900.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 40,120,226.00 | 48,100,994.81 |
| 35100 | Түүхий эд материал | 19,800,652.64 | 24,474,887.23 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,954,335.00 | 4,384,508.00 |
| 35130 | Эм боох материал | 15,846,317.64 | 20,090,379.23 |
| 35400 | Хангамжийн материал | 20,319,573.36 | 23,626,107.58 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,567,312.73 | 1,088,242.73 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,231,615.35 | 18,655,608.85 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 905,000.00 | 905,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,078,475.53 | 638,300.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 12,100.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 525,069.75 | 2,338,956.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,008,831,994.74 | 1,108,280,721.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,008,831,994.74 | 1,108,280,721.11 |
| 39200 | Биет хөрөнгө | 994,672,828.09 | 1,094,205,154.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 964,925,476.49 | 964,925,476.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -34,898,537.31 | -53,182,303.59 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 42,466,833.00 | 85,466,833.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -22,995,640.98 | -22,995,640.98 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 99,536,193.71 | 178,048,406.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -79,745,534.12 | -83,783,773.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,636,600.00 | 1,636,600.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,594,599.70 | -1,616,599.66 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,994,936.00 | 19,208,668.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -17,994,936.00 | -18,844,548.41 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 25,342,037.00 | 25,342,037.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 14,159,166.65 | 14,075,566.61 |
| 39301 | Програм хангамж | 418,000.00 | 418,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -34,833.35 | -118,433.39 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,776,000.00 | 13,776,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,048,952,220.74 | 1,247,547,036.34 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,096,276.98 | 1,945,858.73 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,096,276.98 | 1,945,858.73 |
| 41300 | Өглөг | 1,096,276.98 | 1,945,858.73 |
| 41360 | Бусад өглөг | 1,096,276.98 | 1,945,858.73 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,096,276.98 | 1,945,858.73 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,047,855,943.76 | 1,245,601,177.61 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,047,855,943.76 | 1,245,601,177.61 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 279,444,472.38 | 279,444,472.38 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | -25,370,430.13 | 172,374,803.72 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -3,470,310.92 | -25,370,430.13 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -21,900,119.21 | 197,745,233.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 793,781,901.51 | 793,781,901.51 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,048,952,220.74 | 1,247,547,036.34 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 463,747,141.41 | 1,014,460,684.71 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 39,604,241.41 | 317,739,694.71 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 39,604,241.41 | 317,739,694.71 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,194,213.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 20,194,213.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 118,226,432.37 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 19,410,028.41 | 199,513,262.34 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 424,142,900.00 | 696,720,990.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 381,262,500.00 | 431,685,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 381,262,500.00 | 431,685,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,113,000.00 | 230,677,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,113,000.00 | 150,106,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 10,922,200.00 | 10,129,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,922,200.00 | 10,129,400.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 30,845,200.00 | 24,228,990.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 30,845,200.00 | 24,228,990.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 485,647,260.62 | 816,715,450.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 485,647,260.62 | 816,715,450.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 481,132,869.16 | 816,715,450.86 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,107,524.84 | 389,568,489.73 |
| 210101 | Үндсэн цалин | 186,216,829.94 | 183,988,570.64 |
| 210102 | Нэмэгдэл | 75,412,116.90 | 123,905,991.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,890,722.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 11,587,856.00 | 36,103,850.12 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 45,570,077.95 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,203,283.70 | 47,515,255.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,241,385.45 | 36,087,316.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,830,488.54 | 3,005,106.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,176,601.53 | 2,404,084.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 557,256.00 | 544,263.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,397,552.18 | 5,474,484.55 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,415,900.00 | 14,245,200.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,434,806.87 | 3,200,024.74 |
| 210302 | Түлш, халаалт | 10,981,093.13 | 10,946,175.53 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 99,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,975,223.68 | 28,279,740.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,970,730.00 | 4,223,985.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,312,120.00 | 13,436,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 423,900.00 | 1,169,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 77,000.00 | 130,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,191,473.68 | 9,319,905.00 |
| 2105 | Нормативт зардал | 53,977,203.17 | 305,075,828.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,237,520.48 | 279,479,327.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 8,739,682.69 | 24,642,500.80 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 954,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,686,700.00 | 2,488,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 627,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,686,700.00 | 1,860,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,022,000.00 | 1,008,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,022,000.00 | 1,008,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 32,761,882.00 | 493,048.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,661,882.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 40,000.00 | 80,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 60,000.00 | 119,250.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 750,000.00 | 43,798.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,983,151.77 | 28,041,489.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,795,310.00 | 5,613,883.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,187,841.77 | 22,427,606.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,514,391.46 | 0.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,514,391.46 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,514,391.46 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -21,900,119.21 | 197,745,233.85 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -21,900,119.21 | 197,745,233.85 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *⁄ төгрөгөөр ⁄*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 279,444,472.38 | 793,781,901.51 | -3,470,310.92 | 1,069,756,062.97 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 279,444,472.38 | 793,781,901.51 | -3,470,310.92 | 1,069,756,062.97 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -21,900,119.21 | -21,900,119.21 |
| 4 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 279,444,472.38 | 793,781,901.51 | -25,370,430.13 | 1,047,855,943.76 |
| 5 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 279,444,472.38 | 793,781,901.51 | -25,370,430.13 | 1,047,855,943.76 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 279,444,472.38 | 793,781,901.51 | -25,370,430.13 | 1,047,855,943.76 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 197,745,233.85 | 197,745,233.85 |
| 8 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 279,444,472.38 | 793,781,901.51 | 172,374,803.72 | 1,245,601,177.61 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 424,142,900.00 | 616,150,090.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 424,142,900.00 | 616,150,090.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 381,262,500.00 | 431,685,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 381,262,500.00 | 431,685,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,113,000.00 | 150,106,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,113,000.00 | 150,106,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 10,922,200.00 | 10,129,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,922,200.00 | 10,129,400.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 30,845,200.00 | 24,228,990.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 30,845,200.00 | 24,228,990.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 421,674,460.00 | 601,905,769.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 421,674,460.00 | 601,905,769.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 417,160,068.54 | 601,905,769.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,107,524.84 | 388,551,407.98 |
| 210101 | Үндсэн цалин | 186,216,829.94 | 182,971,488.89 |
| 210102 | Нэмэгдэл | 75,412,116.90 | 123,905,991.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,890,722.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 11,587,856.00 | 36,103,850.12 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 45,570,077.95 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,203,283.70 | 47,515,255.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,241,385.45 | 36,087,316.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,830,488.54 | 3,005,106.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,176,601.53 | 2,404,084.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 557,256.00 | 544,263.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,397,552.18 | 5,474,484.55 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,257,400.00 | 14,825,024.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,372,306.87 | 3,200,024.74 |
| 210302 | Түлш, халаалт | 6,735,093.13 | 11,475,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 150,000.00 | 150,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,273,600.00 | 27,414,370.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,300,000.00 | 2,498,315.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,616,800.00 | 12,656,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,800.00 | 1,229,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 1,379,185.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,550,000.00 | 9,651,520.00 |
| 2105 | Нормативт зардал | 31,752,400.00 | 112,501,680.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 23,502,400.00 | 85,214,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,750,000.00 | 26,333,180.55 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 954,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,340,000.00 | 3,298,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 1,426,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,340,000.00 | 1,872,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,022,000.00 | 1,008,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,022,000.00 | 1,008,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 34,000,000.00 | 493,048.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32,900,000.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 40,000.00 | 80,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 60,000.00 | 119,250.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 750,000.00 | 43,798.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,203,860.00 | 6,298,983.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,203,860.00 | 6,298,983.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,514,391.46 | 0.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,514,391.46 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,514,391.46 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 2,468,440.00 | 14,244,320.42 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,468,440.00 | 3,649,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,468,440.00 | 3,649,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,468,440.00 | 3,649,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,468,440.00 | 3,649,900.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -2,468,440.00 | -3,649,900.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.00 | 10,594,420.42 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 10,594,420.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *| төгрөгөөр |*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 476,932,200.00 | 455,519,469.85 | 21,412,730.15 | 95.51 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 476,932,200.00 | 455,519,469.85 | 21,412,730.15 | 95.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 476,932,200.00 | 455,519,469.85 | 21,412,730.15 | 95.51 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 344,206,200.00 | 339,037,853.25 | 5,168,346.75 | 98.50 |
| 210101 | Үндсэн цалин | 186,500,000.00 | 177,641,488.89 | 8,858,511.11 | 95.25 |
| 210102 | Нэмэгдэл | 88,000,000.00 | 79,722,436.29 | 8,277,563.71 | 90.59 |
| 210104 | Урамшуулал | 36,226,000.00 | 36,103,850.12 | 122,149.88 | 99.66 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,480,200.00 | 45,570,077.95 | -12,089,877.95 | 136.11 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,467,800.00 | 41,285,405.31 | 5,182,394.69 | 88.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,699,600.00 | 29,857,466.08 | 2,842,133.92 | 91.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,442,100.00 | 3,005,106.98 | 436,993.02 | 87.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,753,600.00 | 2,552,695.86 | 200,904.14 | 92.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,400.00 | 395,651.84 | 292,748.16 | 57.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,884,100.00 | 5,474,484.55 | 1,409,615.45 | 79.52 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,129,400.00 | 10,129,349.74 | 50.26 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,000,000.00 | 2,854,349.74 | -854,349.74 | 142.72 |
| 210302 | Түлш, халаалт | 7,979,400.00 | 7,125,000.00 | 854,400.00 | 89.29 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 150,000.00 | 150,000.00 | 0.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,756,800.00 | 24,312,850.00 | 2,443,950.00 | 90.87 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,300,000.00 | 2,498,315.00 | -198,315.00 | 108.62 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,600,000.00 | 11,156,050.00 | 2,443,950.00 | 82.03 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,800.00 | 1,229,300.00 | 77,500.00 | 94.07 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | 1,379,185.00 | 120,815.00 | 91.95 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,050,000.00 | 8,050,000.00 | 0.00 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 33,500,000.00 | 29,682,080.55 | 3,817,919.45 | 88.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 23,500,000.00 | 23,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,500,000.00 | 5,228,080.55 | 2,271,919.45 | 69.71 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 954,000.00 | 1,546,000.00 | 38.16 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,372,000.00 | 2,572,000.00 | 2,800,000.00 | 47.88 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500,000.00 | 700,000.00 | 2,800,000.00 | 20.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,872,000.00 | 1,872,000.00 | 0.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,300,000.00 | 1,008,000.00 | 1,292,000.00 | 43.83 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,300,000.00 | 1,008,000.00 | 1,292,000.00 | 43.83 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,200,000.00 | 493,048.00 | 706,952.00 | 41.09 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 80,000.00 | 80,000.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 119,250.00 | 750.00 | 99.38 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 750,000.00 | 43,798.00 | 706,202.00 | 5.84 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,000,000.00 | 6,998,883.00 | 1,117.00 | 99.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,000,000.00 | 6,998,883.00 | 1,117.00 | 99.98 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 476,932,200.00 | 466,043,890.00 | 10,888,310.00 | 97.72 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 431,685,500.00 | 431,685,500.00 | 0.00 | 100.00 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 431,685,500.00 | 431,685,500.00 | 0.00 | 100.00 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 12,001,400.00 | 10,129,400.00 | 1,872,000.00 | 84.40 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 12,001,400.00 | 10,129,400.00 | 1,872,000.00 | 84.40 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 33,245,300.00 | 24,228,990.00 | 9,016,310.00 | 72.88 |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 33,245,300.00 | 24,228,990.00 | 9,016,310.00 | 72.88 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 10,524,420.15 | -10,524,420.15 | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 19,030.00 | 49.00 | 18,981.00 | 0.26 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24 | 24 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | 0.00 | 100.00 |

## 2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *⁄ төгрөгөөр ⁄*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 150,036,199.73 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 147,086,199.73 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 147,086,199.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 49,513,554.73 |
| 210101 | Үндсэн цалин | 5,330,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 44,183,554.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,229,850.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,229,850.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,695,675.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 345,675.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,350,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,101,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,601,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 82,819,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 61,714,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,105,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 726,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 726,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 2,950,000.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,950,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 2,950,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 150,106,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,106,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,106,200.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 70,000.27 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 70,000.27 |

## 3. Аудитын тайлан
### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.
Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн болон эмнэлэгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “Ёс зүй, ажлын хариуцлагыг сайжруулах урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмжийг сайжруулах, эх хүүхдийн өвчин эндэгдлийг бууруулах, гамшгийн үед эмнэлэгийн бэлэн байдлыг хангах” гэсэн зорилт тавин ажилласан байна.
Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268, А/387/99 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.
Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.
Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 476.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 198.6 сая төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | хувь |
|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 0 | 10.6 | | |
| Бараа материал | 40.1 | 48.1 | 8.0 | 20.0 |
| Авлага | - | 80.5 | 80.5 | |
| Үндсэн хөрөнгө | 1,008.8 | 1,108.3 | 99.5 | 9.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,048.9** | **1,247.5** | **198.6** | **18.9** |
| Өр төлбөр | 1.1 | 1.9 | 0.8 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,047.8 | 1,245.6 | 197.8 | 18.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,048.9** | **1,247.5** | **198.6** | **18.9** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 10.6 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 80.6 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 20.0 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 40.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 153.2 сая төгрөг, хандиваар 199.5 сая төгрөг нийт 352.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 344.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 48.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 9.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1008.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөрх 3.6 сая төгрөг, хандиваар 117.8 сая төгрөг нийт 122.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 22.4 сая төгрөг, бусад элэгдэл 0.8 сая төгрөгийн элэгдлээр буурч 1108.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр эхний үлдэгдлээс 0.8 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд нийгмийн даатгалын шитгэлийг буруу тооцоолсонтой холбоотой 1.9 сая төгрөгийн төгрөгийн шитмгэлийн өглөг үүсгэсэн байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 197.7 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 39.6 | 317.7 | 278.1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 381.3 | 431.7 | 50.4 |
| Нэмэлт санхүүжилт | 1.1 | 230.7 | 229.6 |
| Орон нутгийн төсвөөс | 10.9 | 10.1 | (0.8) |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас | 30.8 | 24.2 | (6.6) |
| **Үйл ажиллагааны орлого** | **463.7** | **1,014.4** | **550.7** |
| Цалин, шимтгэлийн зардал | 314.3 | 437.0 | 122.7 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 103.2 | 351.3 | 248.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32.7 | 0.4 | (32.3) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 30.9 | 28.0 | (2.9) |
| Урсгал шилжүүлэг | 4.5 | - | (4.5) |
| Хөрөнгийн зардал | - | | - |
| **Үйл ажиллагааны зардал** | **485.6** | **816.7** | **331.1** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | (21.9) | 197.7 | 219.6 |

Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 550.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтыг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 513.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 36.1 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 476.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 476.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 10.8 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сан болон орон нутгаас дутуу ирсэн байна. Тайлант онд 455.5 сая төгрөгийг зарцуулж, 10.5 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 150.0 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 33.6 сая төгрөг, Монголын эмч мэргэжилтнүүдийн холбооноос 0.06 сая төгрөг нийт 183.7 сая төгрөг ирсэн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан байна. Үүнд: цалин шимтгэлд 67.8 сая, тээвэр шатахуунд 1.5 сая, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1.6 сая, эмийн зардалд 54.9 сая, хоол хүнсэнд 21.1 сая, багаж, гэрэл цахилгаанд 0.3 сая, мөнгөн тэтгэмжид 33.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 411 хүнд үзүүлж ЭМДС-аас 254.8 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 174.3 сая төгрөг авч оны эцэст 80.5 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлж 10.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнасан бол ЭМГ-ын даргын 2021.08.25-ны өдрийн 02/849 дугаар тушаалын дагуу 20.1 сая төгрөгийн эмийн нөөцийг бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 33.6 сая төгрөг олгосон байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.3 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 476.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 199.5 сая төгрөгийн бараа материал, 117.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Тус байгууллага нь үндсэн орон тооны жолоочтой бөгөөд цалингийн зардалд 17.0 сая төгрөг олгосон байна. Тайлант онд ЭМЯ-аас 43.0 сая төгрөгийн өртөгтэй УАЗ-фургон авто машин хандиваар ирснийг бүртгэл тайланд тусгасан бөгөөд шатахууны зардалд 11.2 сая төгрөг зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.
Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.
Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 138 мэдээллээс 49 мэдээллийг хугацаанд нь, 89 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа ажил үйлчилгээний мэдээлэл, өмч хөрөнгө, мөнгө зарцуулсан тушаал, шийдвэрийг огт мэдээлээгүй байна.
<u>Шийдвэрлэсэн нь</u>: Зөрчлийг таслан зогсоож Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шардлага хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд дотоод хяналт болон элэгдлээрэ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 2 заалт зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 93.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 4.4 сая төгрөгөнд 2 албан шаардлага, 86.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй 2 материаллаг алдаа, зөрчлийн дүн буюу 4.4 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 4.8 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 **Залруулсан алдаа**

Авто машины засвар үйлчилгээнд зарцуулсан 2.3 сая төгрөгийг санхүүгийн тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан тээврийн хэрэгслээр тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

4.1 **Албан шаардлага**

- ЭМГ-ын даргын 2021.12.21-ны өдрийн А/33 дугаар "Шагнал олгох тухай" тушаалаар оны шилдэг ажилтнаар шалгарсан нэр бүхий 4 ажилтанд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний шагнал, урамшуулалд нийт 2427.1 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Тайлант онд нийгмийн даатгалын шитгэлийг буруу тооцоолон 1.9 сая төгрөгийн шимтгэлийн өглөг үүсгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Үүссэн өглөгийг барагдуулж, цаашид өглөг үүсгэхгүй ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

4.2 **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 83 нэр төрлийн 86.8 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан байна.

*Өгсөн зөвлөмж:* Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасны дагуу арга хэмжээ авч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | | 4 | 93.5 | 1 | 2.3 | | | 2 | 4.4 | 1 | 86.8 |
| дүн | | 4 | 93.5 | 1 | 2.3 | | | 2 | 4.4 | 1 | 86.8 |
| | Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| | | 1 | 0 | | | | | 1 | 0 | 0 | 0 |
| дүн | | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | | **5** | 93.5 | 1 | 2.3 | | | 2 | 4.4 | 1 | 86.8 |